Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

**МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАРИГДСАН "ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ"-ИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС**

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: EIL
Албан тушаал: GENERAL MANAGER
Комиссын гишүүн: M.N. RAVI SANKAR
Холбогдох утас: 88241310

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| SOME TOUCH -UP PAINTING. NEED TO BE DONE. [illegible] | |

| | |
| --- | --- |
| | |
| Шийдвэрлэсэн нь: | |
| Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ M.J.RAVISANKAR / Гарын үсгийн тайлал<br>Огноо: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

**МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАРИГДСАН "НЭВТРЭХ ХААЛГА" БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС**

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Мон-[illegible] консалт ХХК
Албан тушаал: [illegible] инженер, ХАБ-ын захирал
Комиссын гишүүн: А. Бат-Эрдэнэ, Б. [illegible]
Холбогдох утас: 99541122, 99657350

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. Галын усны оруулга шугамын дулаалгын бүрхүүлийг (заавал) аль дагуулан ус оруулахааргүй хийж, засварлах | 1) Усны хамгаалалт хийж засварласан. |
| 2. Мөн хаалт арматур, галын хонх суурилуулж хийж, механик удирдлагыг суурилуулах. Галын усны тэжээгүүр шийдлийг бэхлэх, тэнцүүрлэх суурь бетон [illegible] | 2) Хаалт арматур, галын хонх хийсэн, механик удирдлагыг суурилуулсан. Галын усны тэжээгүүр шийдлийг бэхэлсэн. Тэнцүүрлэх суурь бетон хийсэн. |
| 3. Халаалтын шугамын [illegible] оруулга дээр дулаалгын дутуу шаардлага хангахгүй байна. Узелийн хаалт арматур, шугам, тоног төхөөрөмжийн хаалттуулалт дутуу байна суурилуулах. | 3) Халаалтын шугамын оруулга дээр дулаалгыг EPC-2 төслийн хүрээнд тавьсан. |
| 4. Сантехникийн шахтны дээвэр суурилуулж хийх, мөн дээврийн хар усыг [illegible] бичилт засварлах шаардлагатай. | 4) Шахтын дээвэр суурилуулж хийсэн. |
| 5. Барилга байгууламжийн М-акт бичилт бичгийн бүрдлийг бүрэн болон баталгаажуулах шаардлагатай. | Барилгын М-акт бичилт бичгийг журмын дагуу хийсэн Моса Хан шалгаж, баталгаажуулсан болно. |

| | |
|---|---|
| 6. Галын үсрэг оруулга зөөрх мөн холбоотой шугамыг тасалж хаалтны гадна зүүлгэшка (Tag) хийх шаардлагатай байна. | – Үүрэг даалгавар биелүүлсэн |

Шийдвэрлэсэн нь: Комиссон бүсэд үүрэг даалгавар мөн зөөрх шугамыг биелүүлсэн тохиолдолд ашиглалтад хүлээлгэн өгөхөд татгалзах зүйлгүй.

| | |
|---|---|
| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
| Гарын үсэг: | Гарын үсэг: |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / / Гарын үсгийн тайлал | /А.Батэрдэнэ / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.09.27 | Огноо: 2024.07.26 |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

**МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАРИГДСАН "АЖИЛЧДЫН ХООЛЛОХ ГАЗАР" БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС**

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Мон-Энержи консалт ХХК
Албан тушаал: ЧХЗ-н инженер ; ЭНГ-н захирал
Комиссын гишүүн: А.Батдэлгэр, Б Мандуул
Холбогдох утас: 99541122, 99637350

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. Гадны усны оруулга шугамын дулаалсан дүрмийн залгаасны ам задарсан ус оруулахааргүй хийж, засварлах | 1) Усны холболт хийсэн. |
| 2. Мөн хаалт арматур, гадны хонх цэвэрлэж хийх, механик удирдлагын тохиргоо хийх, гадна усны түгээгүүр суурь бетон хөрснөөс 10-15см илүү гаргаж хийх | 2) Хаалт, арматур, гадны хонх цэвэрлэж хийсэн. Механик удирдлага, гадны усны түгээгүүрийн суурь бетон илүү гаргаж хийсэн |
| 3. Халаалтын шугамын оруулга дээр дулаалгын зузаан шаардлага хангахгүй байна. Үзэлтийн хаалт арматур, шугам хоолой дулаалга дутуу, тоног төхөөрөмжийн хамгаалалт дутуу байна цэвэрлэх | 3) Халаалт шугамын оруулга дээр дулаалга нь EPC-2 төслийн хүрээнд байсан. |
| 4. Сантехникийн шахтын дээр хийж цэвэрлэх | 4) Шахтын дээвэр цэвэрлэж хийв. |
| 5. Барилга бүтээцийн М-ыг, Гарын бичгийн бүрдлийг бүрэн болгож баталгаажуулах шаардлагатай. | Барилгын М-аас Гарын бичгийг зураг хийсэн Мөнх Хан шалгаж баталгаажуулсан байна. |

| | |
|---|---|
| 6. Гонгн болон хаалтуудын цувралын тэслэх хаалтны гадна талд зогсуушка (тал) байх шаардлагатай байна. | |

Шийдвэрлэсэн нь: Дээрх шүүмж болон комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн тохиолдолд ашиглалтад өгөхөд татгалзах зүйлгүй байна.

| | |
|---|---|
| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
| Гарын үсэг: [signature] | Гарын үсэг: [signature] |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / / Гарын үсгийн тайлал | /А.Батдорж / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.05.27 | Огноо: 2024.07.26 |

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

## МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАРИГДСАН "ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ"-ИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Мон-Энержи консалт ХХК
Албан тушаал: ЧХБТ-н инженер, ХМТ-н захирал
Комиссын гишүүн: А. Бат-Эрдэнэ, Б. Мандуул
Холбогдох утас: 99541122, 99637550

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1. Галын усны оруулга шугамын дулаалгын бүрхүүлийн задарсан аш дарааж ус оруулахгүйгээр хийж, засварлах | 1) Усны хамгаалалт хийсэн. |
| 2. Мөн хаалт арматур, галын хонх цоожтой хийх, механик удирдлага цоожтой хийх, Галын усны түгээгүүрийн суурь бетон хөрснөөс 10-15см өндөр гаргаж хийх | 2) хаалт, арматур, галын хонх цоожтой хийсэн. Механик удирдлага, галын усны түгээгүүрийн суурь бетон өндөр гаргаж хийсэн. |
| 3. Холболтын шугамын фланц дээр дулаалгын зузаан шаардлага хангахгүй байна. Үзлэгийн хаалт арматур шугам холбох тоног төхөөрөмжийн тусгаарлалт зураг байхгүй | 3) Холболт шугамын фланц дээр дулаалга нь EPC-г тогтоолтой ажлаар багтсан. |
| 4. Сантехникийн шахтны дээвэр хийгдээгүй | 4) Шахтны дээвэр цутгаж хийсэн. |
| 5. Барилга бүтээцийн м-акт бүрэн бичиг баримт бүрдүүлж ирэх, баталгаажуулах шаардлагатай. | Барилга м-акт бүрэн бичиг, зураг хийсэн Мосса Ян шалгаж, баталгаажуулсан болно. |

| | |
|---|---|
| 6. Гамма болон хамаатны шугамын тасалж хамтын лидра зогсоох (тал) илүү шаардлагатай байна. | |

Шийдвэрлэсэн нь: Өөрийн үүрэг даалгавар болон хамаарсан шийдвэрийг өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх тохиолдолд [illegible] тохиолдох зүйлгүй болно.

| Үүрэг даалгавар өгсөн: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан: |
|---|---|
| Гарын үсэг: [signature] | Гарын үсэг: [signature] |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| / / Гарын үсгийн тайлал | Д.Батдүүрэн / Гарын үсгийн тайлал |
| Огноо: 2024.05.27 | Огноо: 2024.07.26 |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАРИГДСАН "АЖИЛЧДЫН ХООЛЛОХ ГАЗАР" БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: KPIL
Албан тушаал: Design Coordinator
Комиссын гишүүн: Ankit Sandilya
Холбогдох утас: 86063177

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1→ Electrical Room / Equipment room tagging to be done<br>2→ Control / Cable tagging to be assured.<br>3→ Electrical Mat to be installed in front of panels of required ratings.<br>4→ All shaft to be covered | Done |

<table>
<tr><td> </td><td> </td></tr>
<tr><td colspan="2">Шийдвэрлэсэн нь:</td></tr>
<tr><td>Үүрэг даалгавар өгсөн:<br><br>Гарын үсэг:<br><br>/Тамга, тэмдэг/<br><br>/ / Гарын үсгийн тайлал<br><br>Огноо:</td><td>Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br><br>Гарын үсэг:<br><br>/Тамга, тэмдэг/<br><br>/ / Гарын үсгийн тайлал<br><br>Огноо:</td></tr>
</table>

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

## МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАРИГДСАН "ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ"-ИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: Kalpataru Projects International Limited
Албан тушаал: Design, Engineering Coordinator
Комиссын гишүүн: Ankit Sandilya
Холбогдох утас: 86063177

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1) North side & south side crack on facade to be rectified/Painted.<br>2) Panel earthing to be tightened.<br>3) External fire piping pipe foundation to be made properly. | Done |

| | |
|---|---|
| | |
| Шийдвэрлэсэн нь: | |
| Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: | Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо: |

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах дүрмийн 4 дүгээр хавсралт

# МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БАРИГДСАН "НЭВТРЭХ ХААЛГА" БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХУУДАС

(Ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийн хамт хүчинтэй)

Байгууллага: KPZL
Албан тушаал: Design Coordinator
Комиссын гишүүн: Ankit Sandilya
Холбогдох утас: 86063177

| Гишүүнээс өгсөн үүрэг даалгавар | Биелэлт |
|---|---|
| 1) Fire external line pipe support foundation to be made properly. | Done |

<table>
<tr><td></td><td></td></tr>
<tr><td colspan="2">Шийдвэрлэсэн нь:</td></tr>
<tr><td>Үүрэг даалгавар өгсөн:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо:</td><td>Үүрэг даалгаврын биелэлт шалгасан:<br>Гарын үсэг:<br>/Тамга, тэмдэг/<br>/ / Гарын үсгийн тайлал<br>Огноо:</td></tr>
</table>

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр №  Алтанширээ сум

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт орших "МГТБҮ" ТӨХХК-ийн "EPC01" багц ажлын технологийн бус барилга "Нэвтрэх хаалга, Эмнэлгийн анхны тусламжийн барилга, Ажилчдын хооллох газар"-ын барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хурлыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 14.00 цагт Газрын тос боловсруулах үйлдвэрийн талбайд "Ажилчдын хоолны газар"-ын зааланд хуралдав.

Хурлыг комиссын дарга Ц.Баярмаа нээж, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, Дорноговь аймгийн Засаг даргын 2024 оны А/451 дүгээр захирамжаар томилогдсон "МГТБҮ" ТӨХХК-ийн "EPC01" багц ажлын технологийн бус барилга "Нэвтрэх хаалга, Эмнэлгийн анхны тусламжийн барилга, Ажилчдын хооллох газар"-ын барилга байгууламжуудын барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг танилцуулав.

Хуралд оролцсон нь:

**Комиссын дарга:**
Ц.Баярмаа (Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

**Нарийн бичгийн дарга:**
Б.Батхишиг ("МГТБҮ" ТӨХХК-ийн технологийн хяналтын ахлах инженер)

**Гишүүд:**
Б.Содномпэл (Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)
Ч.Чулуунцэцэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга, Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч)
Н.Гарамжав ( Аймгийн Засаг даргын тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
Л.Бямбатуяа (Аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)
Г.Ганбаяр (Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

**Хангагч байгууллага:**
Б.Батсүрэн ("БЗӨБЦТС"ТӨХК-ий харьяа Дорноговь аймаг дахь Цахилгаан түгээх сүлжээний салбарын ерөнхий инженер)

**Захиалагч байгууллага:**
Н.Дүгэрсүрэн ("МГТБҮ" ТӨХХК-н Дэд бүтэц, хотхоны газрын дарга)

Б.Энхбат ("МГТБҮ" ТӨХХК-н Техникийн хяналтын албаны дарга)
А.Баяржаргал ("МГТБҮ" ТӨХХК-н Төлөвлөлтийн инженерийн албаны дарга)
Н.Нямпүрэв ("МГТБҮ" ТӨХХК-н Эрчим хүч хариуцсан ахлах инженер)

Т.Тулга-Очир ("МГТБҮ" ТӨХХК-н Гэрээний хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн)

**Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч:**
М.Н.Рави Шанкар ("И Ай Эл" компаний Ерөнхий менежер)

**Зураг төсөл зохиогч:**

А.Бат-Эрдэнэ ("Мон-Энержи консалт" ХХК УХАТ инженер)

Б.Мандуул ("Мон-Энержи консалт" ХХК ХМГ-н захирал)

**Гүйцэтгэгч:**
Анкет Сандиля ( "Калпатару прожектс интернашонал лимитед"-н Зураг төсөл, инженерийн зохицуулагч)

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:**

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт орших "МГТБҮ" ТӨХХК-н "EPC01" багц ажлын технологийн бус барилга байгууламжийн эхний хэсгийн "Нэвтрэх хаалга, Эмнэлгийн анхны тусламжийн барилга, Ажилчдын хооллох газар"-ын барилга байгууламжийн ажлыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн санал дүгнэлтийг хэлэлцэх

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

**Комиссын дарга Ц.Баярмаа:**

Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт орших "МГТБҮ" ТӨХХК-ийн "EPC01" багц ажлын технологийн бус барилга "Нэвтрэх хаалга, Эмнэлгийн анхны тусламжийн барилга, Ажилчдын хооллох газар"-ын барилга байгууламжийн ажилд "МГТБҮ" ТӨХХК-с ирүүлсэн хүсэлтийн дагуу комисс ажиллаж байна.

Өнөөдөр бид Дорноговь аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/451 дүгээр захирамжаар байгуулагдсан улсын комиссын бүрэлдэхүүнээр "МГТБҮ" ТӨХХК-ийн "EPC01" багц ажлын технологийн бус барилга "Нэвтрэх хаалга, Эмнэлгийн анхны тусламжийн барилга, Ажилчдын хооллох газар"-

ын барилга байгууламжийн ажлыг газар дээр нь үзэж шалган, холбогдох баримт материалтай танилцлаа.

Гишүүд санал дүгнэлтээ хэлнэ үү.

**Барилга, хот байгуулалтын яамны Салбарын хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч Б.Содномпэл:**
Эмнэлгийн анхны тусламжийн барилга

- Хашлага хананд малгайвч төмөр хийх.
- Хар цаасан хучлага хавагнаж хөндийрсөн солих.
- Агааржуулалтын хоолой, сангийн шугам хоолойн хонгилд малгайвч төмөр хийх.
- Сангийн шугам хоолойн хонгилд орох хэсэгт шат хийх.

Нэвтрэх хаалганы барилга

- Дээврийн хэсгийн дутуу ажил дуусгах.
- Агааржуулалтын хоолой сангийн шугам хоолой хэсэгт малгайвч төмөр хийх.

Ажилчдын хооллох газрын барилга

- Хар цаасан хучлага хавагнасан хөндийрсөн солих.
- Хашлага хананд малгайвч төмөр хийх.
- Агааржуулалтын хоолой сангийн шугам хоолойн хонгилд малгайвч төмөр хийх.
- Сангийн шугам хоолойн хонгил руу орох хэсэгт шат хийх.

**Аймгийн Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга, архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч Ч.Чулуунцэцэг:**
Эмнэлгийн анхны тусламжийн барилга

- Барилгын зураг төслийн баримт эх хувиар бүртгүүлэн төрийн архивд хүлээлгэн өгөх.
- Аймгийн төрийн архиваас зөвлөгөө авч баримтыг зураг төслийн баримтаар хадгалалтын нэгж бүрдүүлэх.
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж, гэрэл зургаар баталгаажуулах.

Нэвтрэх хаалганы барилга:

- Ил далд ажлын актыг бүрэн бичиж баталгаажуулах.
- Ил далд ажлын гэрэл зургийг "DVD"-нд хуулж өгөх.
- Зураг төслийн баримт бичгийг эх хувиар бүртгүүлж төрийн архивд хүлээлгэн өгөх.
- Зураг төслийн баримт бичгээр хадгаламжийн нэгж бүрдүүлэхэд архивын тасгаас зөвлөгөө авч, шаардлага хангасан баримт бичгийг хүлээлгэн өгөх.

Ажилчдын хооллох газрын барилга

- Барилгын ил далд ажлын актыг дутуу бөглөсөн байгаа тул гүйцээж бичиж баталгаажуулах.

- Тоног төхөөрөмж, суурь хийсэн ба тоног төхөөрөмжийг байрлуулж угсарсан актад хар цагаан гэрэл зураг хавсаргасан байгаа өнгөт гэрэл зураг болгох, Сайншанд гэснийг Алтанширээ болгож засах.
- Хувийн хэргийн баримт бичгийн бүрдэл дутуу байгааг эх хувиар бүрдүүлэх.
- Барилгын зураг төслийн баримт бичгийг эх хувиар бүрдүүлэн төрийн архивд хүлээлгэж өгөх.
- Ил далд ажлын гэрэл зургийг "DVD"-нд хуулж өгөх.
- Ашигласан материалын гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, ашиглалтын зааврыг бүрдүүлж, чухал шаардлагатайг баталгаат орчуулгын товчоогоор орчуулга хийлгэх.
- Гүйцэтгэгч болон туслан гүйцэтгэгч байгууллагын холбогдох баримт бичгийг бүрдүүлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, Инженер техникийн ажилтан томилсон тушаал дипломын хуулбар/
- Хурлын тэмдэглэл, харилцсан бичиг, мэргэжлийн байгууллагын дүгнэлт зөвлөмжийг бүрдүүлж хувийн хэрэгт оруулах.

**Аймгийн Засаг даргын тамгын газрын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Н. Гарамжав:**

Эмнэлгийн анхны тусламжийн барилга

- Узелийн цахилгаан кабель шалаар байгаа нь ус алдахад гэмтэх эрсдэлтэй тул ус зайлуулах трап хийх шаардлагатай байна.
- Барилгын аянга зайлуулга тоног төхөөрөмжийн газардуулгын эсэргүүцлийг мэргэжлийн байгууллагаар шалгуулж баталгаажуулсан протоколыг бичигт баримтад оруулах, буултыг хананаас хөндий дэр хийх.
- Цахилгааны самбаруудад нэр хаяг, анхааруулах санамж плакат хийх.
- Монометр, термометрийн баталгаажуулсан бичиг баримт хавсаргах.
- Дулааны узелийн өрөөний шугам хоолойг дулаалж өнгийн туузаар ороох.

Нэвтрэх хаалганы барилга

- Барилгын аянга зайлуулагч тоног төхөөрөмжийн газардуулж эсэргүүцлийг мэргэжлийн байгууллагаар хэмжүүлж баталгаажуулсан протоколыг баримт бичигт хавсаргах, аянгын буултыг хананаас хөндий дэр хийх.
- Цахилгаан самбаруудад нэр хаяг, санамж плакат хийх.
- 0,4 кВ-ын ерөнхий шитний өрөөнд резин дэвсгэр хийх.

Ажилчдын хооллох газрын барилга

- Дулааны узелийн өрөөний шугам хоолойг дулаалж өнгийн туузаар ороох.
- Цахилгаан самбаруудад нэр хаяг хийх.
- 0,4кВ-ын ерөнхий шитний реле хамгаалалт шалгасан протокол хавсаргах, тавил тооцоо, схем зураг үзүүлэх.
- Барилгын газардуулгын протокол байхгүй байна. /хавсаргах/
- Аянга зайлуулагчийн буултыг зориулалтын дэр хийж бэхлэх холболтуудыг шалгаж бэхлэх.
- Мимбаран клапан гүйцээж хийх
- Монометр, термометрийг баталгаажуулалт.

- "UPS"-г өрөөний кондишены розетка гаргах ашиглалтын зааврыг боловсруулж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх.

**Аймгийн Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Л.Бямбатуяа:**

Эмнэлгийн анхны тусламжийн барилга

- Бохир усны анхны худгийн тагийг дулаалж битүүмжлэлийг сайжруулах.
- Гадна тохижилтыг ажлыг гүйцээж хийх. Барилгын болон ахуйн хог хаягдлыг бүрэн цэвэрлэн Сайншанд сумын Байгаль орчны мэргэжилтний зааж өгсөн хог хаях цэгт зайлуулан баримтжуулна.
- Дээврийн хар цаас наалтыг сайжруулах.
- Душны өрөөний шалны уклон, усны хоолойг доошлуулан ус бүрэн урсах боломжийг бүрдүүлэх.
- Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчид зориулсан ариун цэврийн өрөөний тоноглолыг зөв болгож стандартын дагуу хийх.
- Бохир усны септик танкийг ил далд ажлын актыг үзүүлэх.
- Цэвэр усны нэгдсэн сангийн усны машин ус шахах хэсгийн битүүмжлэх.
- Цэвэр усны нэгдсэн сангийн дээд амсар хоолойг битүүмжилж шороо тоос орохоос сэргийлэх.

Нэвтрэх хаалганы барилга

- Гадна тохижилтыг ажлыг гүйцээж хийх. Барилгын болон ахуйн хог хаягдлыг бүрэн цэвэрлэн Сайншанд сумын Байгаль орчны мэргэжилтний зааж өгсөн хог хаях цэгт зайлуулан баримтжуулах
- Бохирын анхны худгийн тагийг дулаалах битүүмжлэлийг сайжруулах.
- Дээврийн хар цаасны наалтыг сайжруулж, борооны ус зайлуулах хоолойн дээд хэсгийг гадны хатуу хог хаягдлыг орохоос сэргийлэн хамгаалалт хийх.
- Унд ахуйн хэрэгцээний усыг ус нөөцлөх савнаас авч шинжилгээнд хамруулах шинжилгээний дүнг актад хавсаргах.
- Бохир ус зайлуулах септик танкийн ил далд ажлын акт, фото зургийг хянуулах актад хавсаргах.
- Сангийн шугам хоолойн шахтны дээд талыг битүүмжлэх.

Ажилчдын хооллох газрын барилга

- Барилгаас гарсан хог хаягдлыг бүрэн цэвэрлэж орон нутгийн удирдлагын заасан цэгт зайлуулан баримтжуулах.
- Халуун боловсруулалтын хэсгийн агааржуулалтын системийн зургийн дагуу хийх.
- Унд ахуйн хэрэгцээний уснаас дээж авч аймгийн СХЗХ-ны лабораторийн шинжлүүлэх шинжилгээг актад хавсаргах.
- Бохир усны ажил үзлэгийн худгийн тагийг битүүмжийг сайжруулах.
- Удирдлагын ажилчдын хооллох хэсгийн шалны хулдаасны завсрыг чигжих.
- Гал тогооны угаалтуур, тосгуур холбох бохир усны шугам тодорхойгүй, зөвхөн траптай байна. Бохир усны дотор шугам хоолой угсрах.

**Онцгой байдлын газрын ГТУХяналтын байцаагч, хошууч Г.Ганбаяр:**

Эмнэлгийн анхны тусламжийн барилга

- Барилгад ашиглагдсан материалын галд тэсвэрлэлтийн зэргийг ОБЕГ-ийн харьяа ГСҮХүрээлэнгээр гаргуулах. /Дулаалгын хөөсөнцөр, эрдэст хөвөн, галаас хамгаалах хаалга, дохиоллын системийн дамжуулах утас гэх мэт/
- Аянга зайлуулагч, газардуулгын эсэргүүцлийг хэмжүүлж баталгаажуулах.
- Аянга зайлуулагчийн хүрээг металл хийц болон барилгаас хөндийрүүлэх.
- Аврах гарцын гэрэлтэгч тэмдэг тэмдэглэгээ байрлуулах.
- Аврах гарцын чиглэл заасан тэмдэглэгээг гэрэлтэгч тэмдэглэгээгээр солих.
- Галын дохиолол болон гал унтраах системийн туршилт тохируулга хийж актаар баталгаажуулах.

Нэвтрэх хаалганы барилга

- Барилгад ашиглагдсан материалын галд тэсвэрлэлтийн зэргийг ОБЕГ-ын харьяа ГСҮХүрээлэнгээр гаргуулах. /дулаалгын хөөсөнцөр, эрдэст хөвөн, галаас хамгаалах хаалга, дохиоллын системийн дамжуулах утас, өнгөлгөөний металл хавтан гэх мэт/
- Аянга зайлуулагч, газардуулгын эсэргүүцлийг хэмжүүлж баталгаажуулах.
- Аянга зайлуулагчийн хүрээг металл хийц болон барилгаас хөндийрүүлэх.
- Аврах гарцын гэрэлтэгч тэмдэг тэмдэглэгээг гарц бүрт байрлуулах.
- Аврах гарцын чиглэл заасан тэмдэглэгээг гэрэлтэгч тэмдэглэгээгээр солих.
- Галын дохиолол болон гал унтраах системийн туршилт тохируулга хийж акт болон видео баталгаажуулах.

Ажилчдын хооллох газрын барилга

- Барилгад ашиглагдсан материалын галд тэсвэрлэлтийн зэргийг ОБЕГ-ын харьяа ГСҮХүрээлэнгээр гаргуулах. /Дулаалгын хөөсөнцөр, эрдэст хөвөн, галаас хамгаалах хаалга, дохиоллын системийн дамжуулах утас, өнгөлгөөний металл хавтан гэх мэт/
- Аянга зайлуулаг, газардуулгын эсэргүүцлийг хэмжүүлж баталгаажуулах.
- Аянга зайлуулагчийн хүрээг металл хийц болон барилгаас хөндийрүүлэх.
- Галын дохиолол болон унтраах системийн туршилт тохируулга хийж актаар баталгаажуулах.
- Аврах гарцын гэрэлтэгч тэмдэг тэмдэглэгээ байрлуулах.
- Чиглэл заасан тэмдэг тэмдэглэгээг гэрэлтэгч тэмдэглэгээгээр солих.
- Гал гарах эрсдэл байна.
  Удирдлагын шүүгээнд гал унтраах автомат /бөмбөг/ гал унтраагуур байрлуулах.

**"БЗӨБЦТС"ТӨХК-ий харьяа Дорноговь аймаг дахь Цахилгаан түгээх сүлжээний салбарын ерөнхий инженер Б.Батсүрэн**

Эмнэлгийн анхны тусламжийн барилга

- Цахилгааны шитьний өрөөнд шуурхай ажиллагааны схем зураг байхгүй.
- Тоноглол тус бүрт нэр хаяг байхгүй.

- Газардуулгын төмөр хийц будах.
- Аянга зайлуулагчийн төмөр хийц өөрчлөх тусгаарлагч хийх.
- Дээвэр дээр аянга зайлуулагчийн төмөр хийц өөр хооронд нь гагнах.
- Цахилгааны шитьний өрөөнд хамгаалах хэрэгсэл аюулгүй ажиллагааны плакат тавих.
- Цахилгааны шитьний өрөөнд резинэн дэвсгэр дэвсэх.
- Шитьний өрөөнд цахилгааны монтаж цэвэр усны шугамтай хамт шалаар явсанг тусгаарлах.
- Цахилгааны өрөөнд ус чийг мэдрэх дохиолол суурилуулах.
- Аянгын буулт тогтоосон хийц өөрчлөх.
- Шитьний газардуулга болон аянга зайлуулах газардуулгын хэмжилт хийсэн протокол хийлгэх, хэмжүүлэх.
- Цахилгааны шитьний тоноглолын ашиглалтын заавар боловсруулах монгол хэл дээр орчуулах.

Нэвтрэх хаалганы барилга

- Цахилгааны шитьний өрөөнд шуурхай ажиллагааны схем зураг байхгүй.
- Тоноглол тус бүрт нэр хаяг монгол хэл дээр өгөх, бичих.
- Газардуулгын төмөр хийц будах.
- Аянга зайлуулагчийн төмөр хийц өөрчлөх тусгаарлагч хийх.
- Дээвэр дээр аянга зайлуулагчийн төмөр хийц өөр хооронд нь гагнах.
- Цахилгааны шитьний өрөөнд хамгаалах хэрэгсэл аюулгүй ажиллагааны плакат байршуулах.
- Цахилгааны шитьний өрөөнд резинэн дэвсгэр хийх байрлуулах.
- Шитьний өрөөнд цахилгааны монтаж цэвэр усны шугамтай хамт шалаар явсныг өөр хооронд нь тусгаарлах.
- Цахилгааны өрөөнд ус чийг мэдрэх дохиолол суурилуулах.
- Аянгын буулт тогтоосон хийц өөрчлөх.
- Шитьний газардуулга болон аянга зайлуулах газардуулгын хэмжилт хийсэн протокол хийлгэх, хэмжүүлэх.
- Цахилгааны шитьний тоноглолын ашиглалтын заавар боловсруулах монгол хэл дээр орчуулах

Ажилчдын хооллох газрын барилга

- Цахилгааны шитьний өрөөнд шуурхай ажиллагааны схем зураг байхгүй.
- Тоноглол тус бүрт нэр хаяг байхгүй.
- Газардуулгын төмөр хийц будах.
- Аянга зайлуулагчийн хийц өөрчлөх тусгаарлагч суурь хийх.
- Дээвэр дээр аянга зайлуулагчийн төмөр хийц өөр хооронд нь гагнах. Төмөр шатнаас тусгаарлах.
- Дотор шитьний өрөөнд газардуулгын холболт сул байгааг чангалах.
- Цахилгааны ерөнхий шитьний өрөөнд хамгаалах хэрэгсэл аюулгүй ажиллагааны плакат байршуулах.
- Цахилгааны ерөнхий шитьний өрөөнд резинэн дэвсгэр тавих.
- Реле хамгаалалтын ажиллагаа шалгаж тавил тооцоо бодуулах, протокол авах.

- Цахилгааны монтаж цэвэр усны шугамтай хамт шалаар явсныг тусгаарлах.
- Цахилгааны өрөөнд ус зайлуулах шуудуу суваг гаргах.
- Цахилгааны өрөөнд ус чийг мэдрэх дохиолол суурилуулах.
- Аянгын буулт тогтоосон хийц өөрчлөх.
- Шитьний газардуулга болон аянга зайлуулагчийн газардуулгад хэмжилт хийлгэж протокол хийлгэх, хэмжүүлэх.
- Цахилгааны шитьний тоноглолын ашиглалтын заавРыг боловсруулах монгол хэл дээр орчуулах.

**Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Ц.Баярмаа:**

Эмнэлгийн анхны тусламжийн барилга

- Барилгын дээвэрт тогтсон ус бүрэн зайлахгүй байдалтай ул мөр үлдсэн байна. Дээврийг дахин засварлах.
- Шугам хоолойн шахтны хэсгийн хучилтыг хийж дулаалах. Мөн шугам хоолойг дулаалах.
- Барилгуудын гадна цэвэр усан хангамжийн шугам газар дээр ил угсарсан Хөлдөлтөөс хамгаалж халаах кабель утас, дулаалга хийсэн байна. Ашиглалтын явцад баталгаат хугацаанд гарсан эвдрэл гэмтлийг гүйцэтгэгч бүрэн хариуцах талаар албан баталгаа гаргаж өгөх. /Зөөврийн усан хангамжтай/
- Дулааны эх үүсвэр цэвэрлэх байгууламж дараагийн үе шатны ажлуудад орж байгаатай холбоотойгоор цахилгаан халаах хэрэгсэл, септик танк хийсэн байна.
- Бохир усны худагт дулаалгатай модон таг хийх.
- Дээврийн ус зайлуулах трапд хог шороо орохоос хамгаалж /шүүр/ сетка хийх.
- Нөөц усны савнаас ус алдсаны улмаас таазны эмульс хууларсан байна. Засварлах.
- Бичиг баримтын бүртэл дутуу байгааг гүйцээх. /Ил далд ажлын акт, фото зураг дутуу/
- Ил далд ажлын актыг зураг төсөл зохиогчоор баталгаажуулах.
- Агааржуулалтын систем тоног төхөөрөмж, халаалтын тоноглолын техникийн паспорт ашиглалтын заавРыг монгол хэл дээр хөрвүүлэх.
- Барилга байгууламж, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг гарган ГХБХБГ-ын мэдээллийн санд бүртгүүлэх.

Нэвтрэх хаалганы барилга

- Баримт бичгийн бүрдлийг бүрэн хангах.
- Зураг төсөл зохиогчоор ил далд ажлын актыг бүрэн баталгаажуулах.
- Дээврийг дахин засварлах, усыг бүрэн зайлуулах арга хэмжээ авах, ус зайлуулах трапны амсар хэсэгт шүүр хийх. /хог шороо орж битүүрэхээс сэргийлэх/
- Шугам хоолой явж буй шахтны сувгийн дээврийг хийж дулаалах, шугам хоолойг зэврэлтээс хамгаалж будах, дулаалга хийх.
- Гадна цэвэр усны шугам газар дээр ил угсрагдсан хөлдөлтөөс хамгаалж дулаалга хийж халаалтын кабель утас хийсэн байна. Баталгаат 4 жилийн

хугацаанд хөлдөх эрсдэл үүсвэл хариуцан засварлах талаар баталгааг албан бичгээр гаргах.

Усны эх үүсвэр ашиглалтад ороогүй тул зөөврийн усан хангамжтай.

- Дулааны эх үүсвэр, цэвэрлэх байгууламжийн ажлууд нь төслийн дараагийн үе шатанд хийгдэх тул цахилгаан халаалт, септик танк түр ашиглахаар шийдвэрлэсэн байна.
- Халаалтын систем, агааржуулалтын систем ашиглалтын зааварчилгааг монгол хэл дээр хөрвүүлэх, техник ашиглалтын паспортыг хүлээлгэн өгөх.
- Заслын жижиг алдаатай ажлуудыг засварлах.
- Галын гидрант, халуун ус барилга руу орох ил шугамд битүүмж хийх.
- Барилгын гадна фасадны цууралтыг засварлах.
- Барилга байгууламж шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг гаргаж ГХБХБГ-ын ХБКМС-нд бүртгүүлэх.

Ажилчдын хооллох газрын барилга

- Баримт бичгийн бүрдлийг бүрэн хангах
- Зураг төсөл зохиогчоор ил далд ажлын актыг бүрэн баталгаажуулах.
- Гал тогооны халуун цехийн агааржуулалтын системийн далдлагдсан ажлын фото зургийг баримтад хавсаргах.
- Дээврийг дахин засварлах. /хар цаас хөндийрсөн, ус тогтсон байдалтай байна./
- Дээврийн ус зайлуулах трапд хог шороо орохоос хамгаалж шүүр хийх.
- Агааржуулалтын систем тоног төхөөрөмжийн техникийн паспорт, ашиглалтын зааварчилгааг монгол хэл дээр хөрвүүлж ашиглалтад хүлээлгэн өгөх.
- Цахилгаан халаалтын систем тоноглолын техникийн ашиглалтын зааварчилгааг монгол хэл дээр хөрвүүлж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх.
- Барилга байгууламж, шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг гаргуулж ГХБХБГ-ын ХБКМС-нд бүртгүүлэх.
- Барилга тус бүрийн төсөв, өртгийн задаргааг гаргаж "МГТБҮ"ТӨХХК-нд хүлээлгэн өгөх.

**"МГТБҮ" ТӨХХК-ийн Дэд бүтэц, хотхоны газрын дарга Н.Дүгэрсүрэн:**

Эмнэлгийн анхны тусламжийн барилга

- Усанд орох төхөөрөмж байгаа боловч халуун усаар хангах бойлер байхгүй байна.
- Гадна фасадны нүх сүвийг дарах. Засах
- Бохир усны хаялганд үл буцах байрлуулах үнэр дарах.

Нэвтрэх хаалганы барилга

- Усанд орох кабин шүршүүр байгаа боловч халуун усаар хангах бойлер байхгүй байна.
- Гадна фасадны нүх сүвийг дарах. Засах
- Бохир усны хаялганд үл буцах байрлуулах үнэр дарах.

Ажилчдын хооллох газрын барилга

- Усанд орох кабин шүршүүр байгаа боловч халуун усаар хангах бойлер байхгүй байна.
- Гадна фасадны нүх сүвийг дарах. Засах
- Бохир усны хаялганд үл буцах байрлуулах үнэр дарах.

**"МГТБҮ" ТӨХХК-ийн Техникийн хяналтын албаны дарга Б.Энхбат:**

Эмнэлгийн анхны тусламжийн барилга

